

ДАРХАН-УУЛ АЙМГИЙН ХОНГОР СУМЫН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

202... оны ....-р сарын...-ны өдөр

Дугаар.....

Буурал

Бод, бог малын хээлтүүлэгчийг ялган төвлөрүүлж,  
үржилд ашиглуулах, түрээслэх үнэ тогтоох тухай журам

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 48 дугаар зүйлийн 48.1, Малын генетик нөөцийн тухай хуулийн дах 8 дугаар зүйлийн 8.4.3, 8.4.4, 11 дүгээр зүйлийн 11.6.2, 11.6.3, 11.6.4, Хүнс, хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн яамны сайдын 2018 оны А-68 тоот тушаалыг тус тус үндэслэн сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1. Сумын орон нутгийн хөгжлийн сангаар авсан бод, бог малын хээлтүүлэгчийг үржлийн нэгжид төвлөрүүлэн суурилж, малчин, мал бүхий иргэдэд гэрээ түрээсээр ашиглуулах талаар нийтээр дагаж мөрдөх журмыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.

2. Сумын бод, бог малын хээлтүүлэгчийг малчин, мал бүхий иргэдэд гэрээ түрээсээр ашиглуулах үйлчилгээ үзүүлэх үнэ тариф, түрээслэх тоо толгойг 2-р хавсралтаар баталсугай.

3. Сумын малчин, мал бүхий иргэд, хуулийн этгээдэд сайн үүлдрийн ашиг шим өндөртэй хээлтүүлэгчийг гэрээ түрээсээр ашиглуулах, талаар нийтээр дагаж мөрдөх журмыг сурталчилан удирдлага зохион байгуулалтаар ханган хэрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга /Т.Атархишигт/-д даалгасугай:

4. Уг тогтоолыг Хууль зүй, дотоод хэргийн яаманд хүргүүлж бүртгүүлэхийг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын ажлын албаны дарга /Б.Мөнхбаяр/-д даалгасугай.

ДАРГА

Н.ГАНБААТАР

Хонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
202...оны ...дугаар сарын .....-ны өдрийн  
.....дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

## БОД, БОГ МАЛЫН ХЭЭЛТҮҮЛЭГЧ ЯЛГАН ТӨВЛӨРҮҮЛЭХ, ҮРЖИЛД АШИГЛУУЛАХ ЖУРАМ

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Бод, бог малын хээлтүүлэгчийг Мал үржүүлэг технологийн нэгжид шилжүүлэх, малчин, мал бүхий иргэдэд гэрээ түрээсээр ашиглуулах, мэргэжилтний хяналтад авах, үржлийн ажлыг шинжлэх ухааны үндэслэлтэй хөтлөн явуулах, малын үүлдэрлэг байдал, чанарыг сайжруулах нөхцөлийг бүрдүүлэхэд энэхүү журмын зорилго оршино.

1.2. Бод, бог малын хээлтүүлэгч буюу бух, хуц, ухныг /цаашид хээлтүүлэгч гэх/ Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж, мал зүйч мэргэжилтний эзэмшилд шилжүүлж, малчин, мал бүхий иргэдэд мэргэжлийн үйлчилгээ үзүүлэхэд энэхүү журмыг баримтална.

1.3. Хээлтүүлэгч ялган төвлөрүүлж буй нэгж нь мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн нэгж тухайн мэргэжлийн дээд байгууллагаас зөвшөөрөгдсөн байх.

1.4. Хээлтүүлэгч малыг бойжуулж үржилд ашиглах, үржлээс хасах, гэрээ түрээсээр маллуулах ажлыг сумын Хөдөө аж ахуй тасаг, Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж, мэргэжилтэн хамтран /цаашид нэгж гэх/ эрхлэн гүйцэтгэнэ.

1.5 Бод, бог малын хээлтүүлэгчийг малчин, мал бүхий иргэдэд үржлийн хээлтүүлэгч мал түрээслэх ХХААХҮЯ-ны сайдын 2018 оны А-68 тоот тушаалаар баталсан жишиг үнэлгээ, сумын ИТХ-ын тогтоол баримтлан түрээсээр ашиглуулна.

### **Хоёр. Хээлтүүлэгч малыг үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжид шилжүүлэх ажлын зохион байгуулалт**

2.1. Хээлтүүлэгч малыг ялган төвлөрүүлэх, түрээслэхдээ сумын Засаг даргын зөвлөлийн хурлын, санал, санаачилга дээр тулгуурлан зохион байгуулна.

2.2. Мал аж ахуйн салбарт 3 ба түүнээс дээш жил ажилласан, Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнээс үндсэн орлогоо олж байгаа мэргэжлийн үйлчилгээний нэгж хүсэлт гаргасан бол түүнд хээлтүүлэгчийг давуу эрхээр эзэмшүүлж болно.

2.3. Шаардлага хангасан нэгж, мэргэжилтэн хээлтүүлэгч малыг эзэмшин үйл ажиллагаа явуулах тухай хүсэлтээ сумын Засаг даргад Хөдөө аж ахуй тасгаар дамжуулан бичгээр гаргана.

2.4. Сумын Засаг дарга хээлтүүлэгчийг эзэмших тухай хүсэлтийг хүлээн авах эцсийн хугацааг тогтоон зарлах бөгөөд энэ хугацаанд багтаан хүсэлтээ ирүүлсэн нэгжүүдийг тогтоосон хугацаанд сонгон шалгаруулж шийдвэрлэх саналыг сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлж шийдвэр гаргуулна. Уг шийдвэрт Мал үржүүлэг технологийн нэгжид шилжүүлэх хээлтүүлэгч малын тоо, эзэмшүүлэх бэлчээр, уст цэг, хашаа хороог тогтоон өгөх, энэ арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс гаргах тухай зэрэг асуудлыг тусгана.

2.5. Сумын ИТХ-ын шийдвэрийг үндэслэн сумын Засаг дарга энэ ажлыг хэрэгжүүлэх тухай захирамж гаргаж Хөдөө аж ахуйн тасаг, нэгж, мал зүйч оролцуулсан ажлын хэсгийг томилон уг ажлыг гүйцэтгүүлнэ.

2.6. Сумын Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг нийт хээлтүүлэгчид үзлэг аттестатчилал явуулж, үржлийн хээлтүүлэгчийг хувийн дугаар, үржлийн гэрчилгээгээр тусгайлан суурилж, шаардагдах бэлчээр, уст цэг, хашаа хороог тогтоон мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгжид хүлээлгэн өгнө.

2.7. Хээлтүүлэгч малыг эзэмшилдээ авсан мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж, сумын Засаг дарга, хөдөө аж ахуйн тасгийн мал зүйч мэргэжилтэнтэй гэрээ байгуулж мэргэжилтэн нь арга зүйн удирдлагаар хангаж, хамтран ажиллана.

2.8. Хээлтүүлэгчийг мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний нэгж, мэргэжилтний эзэмшилд шилжүүлэхдээ уг ажлын давуу талыг малчдад сурталчлан таниулж зөвшилцөн, гүйцэтгэнэ.

### **Гурав. Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж, мэргэжилтний хүлээх үүрэг, хариуцлага**

3.1. Мал үржүүлэг технологи нэгж, мал зүйч мэргэжилтэн өөрсдийн хариуцсан хээлтүүлэгчийг бүртгэлд авч тусгайлан ялган суурилж, зөвхөн нийлүүлгийн үед календарчилсан төлөвлөгөөний дагуу малчид мал аж ахуй эрхлэгчдэд, гэрээгээр болон түрээслүүлэхдээ зөвхөн сумын ИТХ-ын тогтоолыг баримтлан ашиглуулна.

3.2. Жил бүр хариуцсан хээлтүүлэгчид үзлэг аттестатчилал явуулж, хувийн дугаартай болгох, бүртгэлжүүлэх, гэрчилгээжүүлэх болон заазлах, шинээр нөхөн тавих ажлыг зохион байгуулж, хээлтэгч, хээлтүүлэгчийн тохироог хэвийн хэмжээнд байлгана. Зохиомол болон гардан хээлтүүлгийн аргыг өргөн ашиглаж хээлтүүлэгчийн хүрэлцээ хангамжийг сайжруулна.

3.3. Хээлтүүлэгч малыг үржилд ашиглах, үржлийн ажлын бүдүүвч, тохируулан сонголтыг үйлчилгээний хүрээний айл өрх бүрээр хийж үржил селекцийн ажлын төлөвлөгөөг боловсруулан түүнийгээ мөрдөж ажиллана. Хээлтүүлэгчийг нэг өрхийн сүрэгт 2 жил ашиглаж, 3 дахь жилээс өөр өрхийн сүрэгт ашиглахаар тооцож, сүлжээг малын төрөл, үүлдэр, омгоор гаргасан байна. Хээлтүүлэгчийг үржилд ашиглах хугацаа 5 жилээс илүүгүй байхаар тооцно.

3.4. Цөм сүргийн мал бүхий иргэн, аж ахуйн нэгжтэй гэрээ байгуулан шинээр нөхөн тавих өсвөр хээлтүүлэгчийг сонгож биеийн жин, өсөлт хөгжилт, ашиг шимд нь хяналтын судалгаа явуулж нөхөн тавина.

3.5. Жил бүр хээлтүүлэгчийг мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээнд бүрэн хамруулж эрүүл, стандартын шаардлага хангасан шилмэл хээлтүүлэгчээр малчдад үйлчилж, малын чанар сайжруулах ажлыг хариуцан гүйцэтгэнэ.

3.6. Хээлтүүлэг, төллөлтийн хугацаа, малын ашиг шимийн төрөл тухайн бүс нутгийн онцлог, цаг агаар, зуншлагын байдалтай уялдуулан малчидтай зөвшилцөн жил бүр тогтоож, энэ тухай орон нутгийн Засаг дарга болон иргэдийн хуралд мэдэгдэж шийдвэр гаргуулж байна.

3.7. Хашаа, хороо, өвөлжөө бууц, худаг усны хангамжийг сайжруулж ажиллана.

3.8. Орон нутаг, бүс, улсын хэмжээний гойд ашигт малын үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, шилмэл хээлтүүлэгч оролцуулж суртчилна.

3.9. Мал үржлийн нэгж нь 5 жилийн дараа мал үржлийн улсын байцаагчийн дүгнэлтээр үржлээс хасаж зарж борлуулсан орлогоос өсвөр хээлтүүлэгч нөхөн тавих ажлыг зохион байгуулна.

3.10. Мал үржлийн нэгж нь ЗДТГ-ын бүртгэлтэй хээлтүүлэгч малыг малчнаараа маллуулна.

3.11. Мал үржлийн нэгж нь малчин, мал бүхий иргэнд хээлтүүлэгч түрээсэлсэн мөнгөн дүнгийн 10%-ыг ЗДТГ-ын дансанд төвлөрүүлнэ.

3.12. Мал үржлийн нэгж нь түрээсийн төлбөрт малчдын нийлүүлсэн өсвөр хээлтүүлэгчийг бүртгэлжүүлэн Засаг даргын Тамгын газрын балансад бүртгүүлнэ.

### **Дөрөв. Мал Үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгж, мэргэжлийн мал зүйч мэргэжилтэнд тавигдах шаардлага**

4.1. Тухайн үүлдэр, омог, хэвшлийн малын шилмэл хэсгийн жишигт тэнцсэн малаар цөм сүргийг бүрдүүлж үржлийн мал бойжуулах чиглэлээр ашиглана. Цөм сүргийн малд удам, бүл бий болгож хувьслын ангилалт, тохируулан сонголт хийж үржлийн ажлыг мэргэжлийн түвшинд явуулна.

4.2. Тухайн орон нутгийн малчин, мал бүхий иргэд, аж ахуйн нэгжийн хяналтад байлгаж, нийт хээлтүүлэгч малд жил бүр үзлэг ангилалт хийж, үржилд тэнцэхгүй хээлтүүлэгчийг сүргээс тусгаарлаж хэрэгцээлэх..

4.3. Үржлийн хээлтүүлэгч нь тухайн үүлдэр, үүлдрийн хэсэг, омог хэвшлийн малын ашиг шимийн стандартын доод үзүүлэлтээс 20-40 хувь дээгүүр байх шаардлагыг баримтална.

4.4. Малчин мал бүхий иргэдийн бэлчээрийн мал сүргийг ердийн аргаар хээлтүүлнэ.

4.5 Жил бүр хариуцсан мал эмнэлгийн нэгжийн малын эмчтэй гэрээ байгуулан хавар, намрын тарилга туулгалт, угаалага, ариутгал халдваргүйжүүлэлтэд хээлтүүлэгч малаа бүрэн хамруулна.

4.6 Сумын Засаг дарга болон холбогдох байгууллагуудаас гаргасан шийдвэрүүдийн хэрэгжилт, эрх бүхий байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлэх.

### **Тав. Малчин, мал бүхий иргэдийн хүлээх үүрэг:**

5.1 Сумын малчин, мал бүхий иргэд тухайн үйлчлүүлж байгаа үржлийн ахуйн нэгжтэй гэрээ байгуулан сайн үүлдрийн ашиг шим өндөртэй хээлтүүлэгчийн түрээсийн төлбөрөө аж ахуйн нэгжид төвлөрүүлэн, түрээсээр авч бүртгэлийн дагуу өөрийн биеэр хүлээлгэн өгнө.

5.2 Үржилд ашигласан цөм сүргийн аж ахуйн хээлтүүлэгчээс малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгж өсвөр хээлтүүлэгч сонгон бойжуулж малчин мал бүхий иргэнд хувиараа түрээслэхгүй байх.

5.3 Өөрийн сумын мэргэжилтний зөвшөөрөлгүй үржлийн хээлтүүлэгч худалдан авч үржилд ашиглахыг хориглоно.

5.4 Малчин, мал бүхий иргэн хээлтэгч малаа үнэн зөв гаргаж бүртгэлжүүлэн хээлтүүлгийн тохироогоор хээлтүүлэгчийг үржлийн нэгжээс өөрийн биеэр түрээслэн авна.

5.5 Түрээслэсэн өндөр ашиг шимтэй хээлтүүлэгчийг бусдад шилжүүлэх, давхар түрээслэхгүй байх.

## **Зургаа. Журмын хэрэгжүүлэхэд санхүүжилтийн талаар**

6.1. Мал үржүүлэг технологийн ажил, үйлчилгээний нэгж нь малчид, мал үржүүлэгчдэд хээлтүүлэгч малыг төлбөртэй ашиглуулж / үйлчилгээ үзүүлж/ үйл ажиллагааны орлогоор өөрийгөө санхүүжүүлж аж ахуйн бүрэн тооцоонд ажиллана.

6.2. Хээлтүүлэгч малыг үржилд ашиглуулах төлбөрийн Мал үржүүлэг технологийн ажил үйлчилгээний нэгж, малчидтай зөвшилцөн “Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээнд баримтлах жишиг үнэ”-ийн үзүүлэлтийг харилцан тохиролцож гэрээ байгуулж ажиллана. Төлбөрийг тогтоохдоо хээлтүүлэгч малын арчилгаа маллагаа, малчин, мэргэжилтний цалин хөлс, аж ахуйн чадавхыг сайжруулах зэрэг арга хэмжээнд шаардагдах эх үүсвэрийг бүрдүүлэх тооцоог үндэслэл болгоно. Онцгой ашиг шимтэй, үр төл сайтай хээлтүүлэгч илүү төлбөртэй байж болно.

6.3 Өндөр ашиг шимт бод, бог малын хээлтүүлэгчийг малчдад түрээслэх зардлын үнэ тарифыг ИТХ-ын тогтоолоор тогтоож өгнө.

6.4. Засаг даргын Тамгын газрын өндөр ашиг шимт нэг хээлтүүлэгч бухыг малчин, мал бүхий иргэд хот айлаар /2 өрх/ жил бүр түрээсийн төлбөрт нэг эр бяруу, 200 мянган төгрөгийг мал үржлийн нэгжтэй тооцоо хийнэ.

6.5. Өндөр ашиг шимт мах, ноосны нарийн, нарийвтар Суффольк, Эдельбай үүлдрийн хуцны түрээсийн төлбөрт нэг эр хурга, 100 мянган төгрөг, Баяд, Өлгийн улаан үүлдрийн хуц, ухны төлбөрт 100 мянган төгрөгөөр түрээсэлж мал үржлийн нэгжийн дансанд төвлөрүүлсний дараа хээлтүүлэгч малаа түрээсээр ашиглана.

## **Долоо. Засаг даргын Тамгын газрын үүрэг, хүлээх хариуцлага**

7.1. Үржлийн нэгжид төвлөрсөн хээлтүүлэгчийн арчилгаа, маллагаа, тэжээллэгт ХААТ-ын мэргэжилтнээр дамжуулан хяналт тавьж ажиллах.

7.2. Малчдын малын үүлдэрлэг байдал, ашиг шим нэмэгдсэн байдлыг тоо баримтаар баталгаажуулж иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулж үр дүн тооцох.

7.3. Бог малын хээлтүүлэгчийн суурийг сумын Засаг дарга зусах, намаржих нутгийг хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтнээр дамжуулсан зааж өгнө.

7.4 Өндөр ашиг шимт хээлтүүлэгчийг байгалийн давагдашгүй хүчин зүйл /үер ус, гал түймэр, зэрлэг ан амьтан түүнээс үүсэх халдварт өвчин, зуд/ зэрэгт нэрвэгдсэн үед хариуцсан малын эмчийн үзлэг үндэслэн мал эмнэлгийн тасгийн мал эмнэлгийн улсын байцаагчийн дүгнэлтээр акт баримт бүрдүүлэн балансаас хасах.

7.5 Бог малын хээлтүүлэгчийн үржлийн эрхтэн гадны нөлөөллөөс гэмтэж бэртсэн үед Мал үржлийн албаны улсын байцаагчийн үзлэгийн дүгнэлтийг үндэслэн баланс болон үржлээс хасах.

7.6 Бог малын хээлтүүлэгчийн суурьт өвөлжилтийн бэлтгэл ажил хангахад хадлангийн газар өвс, тэжээлийн дэмжлэг үзүүлэх.

7.7 Хээлтүүлэгчийн түрээслэх зардлын төлбөрийг мал үржлийн нэгжтэй тооцоо хийнэ.

## **Найм. Журмын хэрэгжилтэд хяналт тавих, хариуцлага тооцох, хохирол нөхөн төлүүлэх:**

8.1. Стандартад тэнцсэн үржлийн хээлтүүлэгчийг үржилд ашиглах, гэрээ түрээсээр ашиглуулах ажил, үйлчилгээний чанар ,байдалд мал үржлийн хяналтын улсын байцаагч хяналт тавина. Үүнд:

8.2. Энэ журмыг зөрчсөн малчин, мал бүхий иргэн, аж ахуйн нэгжид “Малын генетик нөөцийн тухай хууль” хуулийн 20 дугаар зүйлийн дагуу хариуцлага тооцно.

8.3. Сумын хөдөө аж ахуйн тасаг, энэхүү журмыг хэрэгжүүлэхэд мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлж, хэрэгжилтэд мөн хяналт тавина.

Хонгор сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын  
202...оны ...дугаар сарын .....ны өдрийн  
.....дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

**БОД, БОГ МАЛЫН ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТӨРӨЛ, ТОО ТОЛГОЙ**

№		Хээлтүүлэгч малын төрөл, тоо толгой, үүлдэр, омог													
1	Бух		Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц			
	Ангус	Үүлдэр											Үүлдэр	Тоо толгой	Үүлдэр
		5			40				5		5				30

**БОД, БОГ МАЛЫН ХЭЭЛТҮҮЛЭГЧИЙН ТӨРӨЛӨӨР, НЭГ ТОО ТОЛГОЙД  
ТҮРЭЭСЛЭХ ҮНЭ /МЯН.ТӨГ/**

№		Хээлтүүлэгч малын төрөл, тоо толгой, үүлдэр, омог													
1	Бух		Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц	Хуц			
	Ангус	Үүлдэр											Үүлдэр	Нэг толгой мал түрээслэх үнэ /мян.төг/	Үүлдэр
		200.000 нэг эр бяруу			100.000 буюу төлөг				100.000 нэг эр хурга		100.000 нэг эр хурга				100.000 нэг эр ишиг